

## **НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү дүрмийн зорилго нь НССДС-ийн Оюутны зөвлөлийн /цаашид Оюутны зөвлөл гэнэ/ үйл ажиллагааг тодорхойлж зохицуулахад оршино.
- 1.2. Оюутны зөвлөлийн дээд эрх нь НССДС-ийн Бүх оюутны хуралд байна.
- 1.3. Оюутны зөвлөл нь Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гишүүддээ үйлчилдэг, сайн дурын үндсэн дээр нэгдсэн, өөрийн удирдлагатай, олон нийтийн, хараат бус, ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулна.
- 1.4. Оюутны зөвлөл нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, сургуулийн захиргаа, алба нэгжтэй хамтран ажиллаж нийт оюутнуудын эрх ашиг, хүсэл эрмэлзлэлийг илэрхийлэн хамгаалж, ажиллана.
- 1.5. НССДС-д суралцаж буй бүх оюутан Оюутны зөвлөлийн гишүүн мөн.
- 1.6. Оюутны зөвлөл нь өөрийн дүрэм, журам, билэг тэмдэг, уриатай байна.

### **ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ ЗОРИЛГО**

- 2.1. Оюутны зөвлөлийн үндсэн зорилго нь оюутны нийтлэг эрх ашгийг төлөөлөн хамгаалж, эрх, үүрэг, сурч боловсрох нөхцөлийг бүрдүүлэхэд оюутнуудын хүсэл зориг, сонирхлыг нэгдмэл байр сууринаас илэрхийлж, тэдний хөгжил дэвшилд чиглэсэн хөгжлийн олон талт ажлыг зохион байгуулна.
- 2.2. Оюутны зөвлөл нь оюутны санаа бодлыг сонсох, оюутнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, сургуулиа хөгжүүлэх үйлсэд оюутны идэвх оролцоог нэмэгдүүлэх, тэднийг хөгжүүлэх, нийгэмшүүлэх, авьяас чадварыг нээн илрүүлэхэд ажлаа чиглүүлэх бөгөөд суралцагчдын үүсгэл санаачлагаар байгуулагдсан клуб, дугуйлан зэргийг дэмжиж, хамтран ажиллана.
- 2.3. Оюутны зөвлөл нь сургуулийн захиргаанаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оюутнуудыг татан оролцуулах, хамтран ажиллах, зохих мэдээллээр хангаж ажиллана.
- 2.4. Оюутны зөвлөл нь МОХ-оос зохион байгуулж буй арга хэмжээнд идэвхтэй оролцох, гадаад харилцааг өргөжүүлэх, төгсөгчид болон ажил олгогч нартай хамтран ажиллахад идэвх, санаачлага гаргана.
- 2.5. Оюутны зөвлөл нь үйл ажиллагаандаа хуулийг дээдлэн, шударга ёс, тэгш эрхийн эрхэмлэн, оюутнуудын эв нэгдлийг хангах, нээлттэй зарчмыг баримтална.
- 2.6. Оюутны зөвлөл нь улс төрийн нам, бүлэглэлээс ангид ажиллана.

## **ГУРАВ. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 3.1. НССДС-ийн Бүх оюутны хурал нь дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, Оюутны зөвлөлийн Тэргүүн, Тэргүүлэгч гишүүдийг нууц санал хураалтаар сонгох, чөлөөлөх, Оюутны зөвлөлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх, үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг эрх, үүрэгтэй.
- 3.2. НССДС-ийн Бүх оюутны ээлжит хурал жил бүрийн 5-р сард болох бөгөөд ээлжит бус хурлыг Оюутны зөвлөлийн шийдвэр, эсвэл нийт оюутны  $\frac{1}{4}$  нь шаардсан тохиолдолд зарлан хуралдуулна.
- 3.3. Оюутны зөвлөл нь Тэргүүн, Тэргүүлэгч гишүүн бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд 3 жилийн хугацаатай сонгогдон ажиллана. Тэргүүлэгч гишүүнээр цагийн хөтөлбөрт суралцаж буй оюутныг сонгож болно.
- 3.4. Оюутны зөвлөлийн Тэргүүн, Тэргүүлэгч гишүүн үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон тохиолдолд ангийн дарга нарыг оролцуулсан өргөтгөсөн хурлаар нөхөн сонгож болно.
- 3.5. Оюутны зөвлөл нь дэргэдээ зөвлөх багш ажиллуулж болно.

### **ДӨРӨВ. ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛ, ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮДИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

- 4.1. Оюутны зөвлөл нь энэхүү дүрмийн хэрэгжилт, ажлын төлөвлөгөөний биелэлтийг багаараа хамтран гүйцэтгэх үйл ажиллагааг хариуцна.
- 4.2. Оюутны зөвлөл нь оюутны хөгжил, эрх ашигт нийцсэн асуудлаар байр сууриа илэрхийлэх, санал бодлоо сургуулийн шийдвэрт тусгуулж, өөрийн үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийн талаар сургуулийн захиргаанд санал хүсэлт, шаардлага тавьж болно.
- 4.3. Оюутны зөвлөлийн тэргүүлэгч гишүүд сард 1-2 удаа, 60%-иас дээш ирцтэй хуралдах бөгөөд шийдвэрийг олонхийн саналаар батална. Хурлаас гарсан шийдвэр нь тогтоол хэлбэрээр гарч, Тэргүүн гарын үсэг зурж, тамга дарсан байна.
- 4.4. Оюутны зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар төлөвлөгөөт болон бусад үйл ажиллагааны талаар хэлэлцэх ба хуралд бусад оюутан оролцож, санал бодлоо хуваалцаж болно. Хуралд тэмдэглэл хөтөлж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 4.5. Сургуулийн удирдлага, багш, ажилтан шаардлагатай тохиолдолд хуралд сууж, санал гаргаж болно.
- 4.6. Хурлаас гарсан шийдвэр, мэдээллийг самбар болон сошиал хуудас, дотоод шуудангаар дамжуулан нийт оюутанд шүүрхай хүргэнэ.
- 4.7. Тэргүүн нь Оюутны зөвлөлийн үйл ажиллагааг шууд удирдлагаар хангаж ажиллах бөгөөд Оюутны зөвлөлийг дотоод, гадаадад төлөөлөх, сургуулийн Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллах, Оюутны зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах, тогтоол шийдвэрийг батлах, Тэргүүлэгч гишүүнд үүрэг, даалгавар өгөх, биелэлтийг хянах, бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.
- 4.8. Оюутны зөвлөлийн Тэргүүлэгч гишүүд нь оюутны хөгжлийн клуб, судалгаа, спорт, соёл, дотуур байр, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, гадаад харилцаа гэх мэт тодорхой чиг

үүрэг хариуцан ажиллаж болно. Тэргүүлэгч гишүүний хариуцах ажил, эрх, үүргийг Оюутны зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлэнэ.

- 4.9. Оюутны зөвлөлийн Тэргүүлэгч гишүүн дараах эрх, үүрэгтэй:
  - 4.9.1. Зөвлөлийн хуралд асуудал хэлэлцүүлэх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
  - 4.9.2. Оюутнуудыг сурлага, соёл, хүмүүжлээрээ үлгэрлэн манлайлах, сайн дурын олон талт үйл, ажилд идэвх, санаачлагатай оролцох, сургуулиас зохиож буй арга хэмжээнд оюутнуудыг оролцуулах, хяналт тавих;
  - 4.9.3. Оюутны сурлага, идэвх, оролцоо, төлөвшил хүмүүжлийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд сургуулийн захиргаанд санал тавих;
  - 4.9.4. Нийт оюутны эрх ашгийг хамгаалж, санал, хүсэлт, гомдол, талархлыг нь сургуулийн захиргаатай хамтран шийдвэрлүүлэх, дотуур байранд амьдардаг оюутнуудын ажилд туслахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах;
  - 4.9.5. Оюутны зөвлөлөөс гаргасан шийдвэр, үриалга, ажлуудыг нийт оюутан суралцагсдад шуурхай, бодитой хүргэж байх;
  - 4.9.6. Дүрэм, дотоод журмаа хатуу чанд мөрдөн ажиллах;
  - 4.9.7. Өөрийн хариуцсан ажлаа чанартай, үр дүнтэй гүйцэтгэх, алдаа гаргавал хариуцлага хүлээх;
  - 4.9.8. Бусад эрх, үүрэг.
- 4.10. Оюутны зөвлөл нь тухайн хичээлийн жилийн зорилт болон ажлын төлөвлөгөө, төсвийг жил бүрийн 9-р сарын 20-ний дотор хэлэлцэж батална.
- 4.11. Оюутны зөвлөл нь уламжлал болгон зохион байгуулдаг үйл ажиллагаатай /хавсралт/ байж болно.
- 4.12. Оюутны зөвлөл нь сургуулийн захиргаа, алба нэгжээс гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, оюутнуудаа манлайлан хамтран ажиллах үүрэгтэй.
- 4.13. Оюутны зөвлөл нь улс, бүс, салбар, сургуулийн хэмжээнд зохиогдох мэргэжлийн, соёл урлаг, спортын үйл ажиллагааг сургуулийн захиргаатай хамтран зохион байгуулах үүрэгтэй.
- 4.14. Оюутны зөвлөл нь ажлаа жил бүрийн 05-р сарын 10-20-ний хооронд Бүх оюутны хуралд тайлагнаж, ажлын тайланг хэвлэмэл байдлаар сургуулийн захиргаанд өгөх үүрэгтэй.

#### **ТАВ. НССДС-ИЙН ОЮУТНЫ ЭРХ, ҮҮРЭГ**

- 5.1. НССДС-ийн оюутан нь Оюутны зөвлөлийн Тэргүүн, Тэргүүлэгч гишүүнд нэрээ дэвшүүлэх, сонгох, сонгогдох эрхтэй.
- 5.2. НССДС-ийн оюутан нь Оюутны зөвлөлд санал, хүсэлт, шаардлага тавих, Оюутны зөвлөлийн зарим үйл ажиллагааг санаачлах, ажлын төлөвлөгөөнд санал оруулах, сонгосон Тэргүүлэгч гишүүдээрээ уламжлан Оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд оролцох, Оюутны зөвлөлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах эрхтэй.
- 5.3. НССДС-ийн оюутан нь энэхүү дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, Оюутны зөвлөлийн үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх эрхтэй.
- 5.4. НССДС-ийн оюутан нь өөрийгөө хөгжүүлэх, хамтран сурч ажиллах, бүтээлч идэвх санаачилгатай байж Оюутны зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх үүрэгтэй.

5.5. НССДС-ийн оюутан нь Оюутны зөвлөлөөс гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, даган биелүүлэх үүрэгтэй.

#### **ЗУРГАА. ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН САНХҮҮЖИЛТ**

6.1. Оюутны зөвлөлийн санхүүжилт нь дараах эх үүсвэртэй байна. Үүнд:

6.1.1. Сургуулийн захиргааны дэмжлэг /сургалтын төлбөрийн орлогын 1,0 хувь/

6.1.2. Хандив, тусламж

6.1.3. Өөрсдийн үйл ажиллагаанаас олсон орлого.

6.2. Оюутны зөвлөл нь төсвийг оновчтой хуваарилан, хамтын шийдвэрээр үр ашигтай захиран зарцуулна.

6.3. Оюутны зөвлөл нь төсвийн зарцуулалт, үр дүнг Бүх оюутны хуралд тайлагнах, сургуулийн захиргаанд танилцуулах үүрэгтэй.

#### **ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ**

7.1. Оюутны зөвлөл нь сургууль дээр ажлын өрөөтэй байх бөгөөд нийт оюутнуудад нээлттэй байна.

7.2. Оюутны зөвлөл нь шаардлагатай бол сургуулийн захиралтай гэрээ байгуулан ажиллаж болно.

7.3. Оюутны зөвлөлийн Тэргүүн, Тэргүүлэгч гишүүнд үзүүлэх урамшуулал, хөнгөлөлтийг сургуулийн захиргаатай хамтран шийдвэрлэнэ.

7.4. Энэхүү дүрэмд Бүх оюутны хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



**НССДС-ИЙН ОЮУТНЫ ЗӨВЛӨЛӨӨС  
ТОГТМОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- Намрын “Эрдмийн баяр”
- Танилцах аялал /үдэшлэг/
- Автобусны карт захиалга
- Оюутны үнэмлэх захиалга
- “Гайхам” танин мэдэхүйн тэмцээн уралдаан
- Кинотой үдэш
- “Эрүүл биед саруул ухаан оршино” аян
- Оюутны хөгжлийн сургалт
- “Номын хэлэлцүүлэг” өдөрлөг
- Цасны баяр
- Оюутны зөвлөлийн Шагналын эзэнг тодруулах
- Шинэ жилийн цэнгүүн
- Сургуулийн мэтгэлцээний тэмцээн
- Нийгэмд тустай хөдөлмөрийн аян
- Спортын наадам, аварга шалгаруулах тэмцээн
- Хаврын “Эрдмийн баяр”
- Оюутны хөгжлийн клубын үйл ажиллагааг дэмжих
- Бусад

2023.10.26